

Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Аймгийн Засаг даргаас Боловсрол, соёлын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

2009 онд Боловсрол соёлын газрын дарга нь аймгийн Засаг даргад тусгай захиалгат 13, тусгай захиалгатаас бусад нийт 50, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 3 ангийн бүтээгдэхүүн нийлүүлэхээр үр дүнгийн гэрээ байгуулсан .

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ерөнхий болон сургалтын менежерүүдийг Боловсролын удирдлагаар мэргэшүүлэх хөтөлбөр, багш нарт “Шилдэг бүтээл”-ийн шагнал олгох журам, “Хөгжсөн багшаас хөгжсөн хамт олон болох” аяны удирдамж, “Нийгмийн түншлэлийн хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдийг боловсруулан батлуулсан байна.

Аймгийн ХЖТ-ыг драмын ангитай болгохоор уран бүтээлчдийн тоог 9 нэмэгдүүлж, орон тоо, цалингийн фондыг 2010 оны төсөвт тусгуулснаас гадна **Төв номын санг интернетэд холбож, цахим номын санд шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэн** сумдын номын сангийн фондод 66 сая төгрөгийн баяжилт хийсэн.

Дээрх арга хэмжээнүүдийн дүнд боловсрол соёлын байгууллагуудын материаллаг бааз нэмэгдэж үйлчилгээ тогтмолжиж бага суурь боловсролын хичээлийн стандарт хангалтын төвшин өнгөрсөн жилээс буураагүй, Ерөнхий шалгалтын дундаж дүн өссөн байна. Албан бус боловсролын сургалтанд 230 хүн хамрагдаж байна.

Өнгөрөгч онд нийт боловсрол соёлын салбарт барилга байгууламж барих, их засвар хийх, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах зэргээр 1.8 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн нь өнгөрсөн оноос 100 гаруй сая төгрөгөөр нэмэгджээ.

2009 онд боловсрол соёлын салбар бүхэлдээ өргүй гарчээ.

БСГ-ын Ерөнхий менежер нь тусгай захиалгат бүтээгдэхүүнийг 85, тусгай захиалгат бүтээгдхүүнээс бусад нийт бүтээгдэхүүнийг 96, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх зорилтыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр биелүүлж нийт дүнгээрээ Үр дүнгийн гэрээгээ 92,2 хувийн гүйцэтгэлтэйгээр “А” буюу “Маш сайн” үнэлгээтэйгээр дүгнэгдсэн байна.

Аймгийн Засаг даргаас Биеийн тамир спортын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Аймгийн Засаг даргатай 2009 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг байгуулан гэрээнд нийт 23 бүтээгдэхүүнийг нийлүүлэхээс зайлшгүй шаадлагатай 8 бүтээгдэхүүнийг тусгай захиалгат болгон авч ажиллаа. Гол үр дүн нь “Хүн бүр өөртөө 30 минут” аяныг өрнүүлэн ажиллаа. Монгол улсын Засгийн газрын 05 тоот тогтоолыг аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган Засаг даргын захирамж гарган аймгийн хэмжээнд өргөн хүрээнд зохион байгуулсан. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 20 төрлөөр зохион байгуулан 16 төрлийн секц дугуйланд 3000 гаран хүүхэд багачууд хамрагдан хичээллэж байна. 2009 оны өсвөрийн цаначдын УАШТ-г Бугат суманд амжилттай зохион байгуулсан зэрэг болно. Манай аймаг 2009

онд нийтдээ 298 хүрэл, 230 мөнгө, 162 алтан медалийн амжилттайгаар үдлээ. Биеийн тамирын спортын газрын дарга нь Засаг даргатай байгуулсан гэрээний үнэлгээгээ 91 хувьтай дүгнүүлж ажиллаа.

Аймгийн Засаг даргаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Гэрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийт 57 бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр 95,8 оноогоор үнэлж дүгнэлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байнгын 820, түр 365 нийт 1185 ажлын байр бий болгосон байна.

Мэргэлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 1024 хүн хамрагдаж, ажилд 932 зуучилсан байна. Зохион байгуулсан нийтийг хамарсан ажил 60, үүнд нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулж 1030 хүн оролцсон байна.

“ХҮМ” программыг 2009 онд эхлүүлэн хэрэгжүүлж мэдээллийн шинэ сан бүрдүүлэн ажиллаж байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4 сумын 30 айл өрхийг хамруулж төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлийн ажилд арга зүйн зөвлөмж туслалцааг өгч бүсчилсэн сургалт зохион байгуулж зөвлөлийн ажилд ахиц гарсан байна.

Аймгийн Засаг даргаас Нийгмийн даатгалын хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга байгуулсан үр дүнгийн гэрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийт 18 бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр 97,5 оноогоор үнэлж дүгнэв.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг улирал бүр 100.1-115.0 хувиар биелүүлэн ажилласан.Тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилтийг бүрэн өгч цаг хугацаанд нь олгосон

Оны эхэнд байсан 24.4 сая төгрөгийн өр авлагыг 12,4 сая төгрөг болгож 10.0 сая төгрөгөөр бууруулсан амжилттайгаар ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас Хүүхдийн төлөө хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Аймгийн Хүүхдийн төлөө хэлтсийн даргын байгуулсан үр дүнгийн гэрээнд байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийт 18 бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр 99,5 оноогоор үнэлж дүгнэв. Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэж “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Хүүхэд хөгжүүлэх оролцоог хангах арга хэмжээний 2009 оны нэгдсэн график гарган аймгийн хэмжээнд нийт 22 хүүхэд хөгжлийн арга хэмжээг зохион байгуулж төв

хөдөөгийн 2000 гаруй хүүхэд хамрагдсан байна. Үүнээс “Цодгор хүү -2009”, “Уран жиргээ-2009”, “Өсвөрийн шилдэг дуучин, бүжигчин -2009”, Англи хэл – Бидний хэл, Замын хөдөлгөөний цагаан толгой, Чансаа – 2009, Бяцхан башьё, Хүүхдийн ертөнц зэрэг 10 гаруй төрлийн уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж 17 сумын 600 гаруй хүүхдүүд хамрагдсан байна.

Аймгийн Засаг даргаас Х ХААЖДҮ газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

ХХААЖДҮ газар гэрээгээр хүлээсэн үүргээ сайн биелүүлж 92,2 хувь буюу А үнэлгээтэй дүгнэгдсэн бөгөөд дараахи ажлуудыг сайн хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн, уринш бэлтгэлийг 77.1 хувь өссөн, техник шинчлэлийг 30 хувь, мал аж ахуйн үйлдвэрлэлийг өмнөх жилээс 8,2 хувь, өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувийн жинг 7 хувьд хүргэсэн.

“Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн ажлыг амжилттай хэрэгжүүлж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж улсын төсвөөс олгосон хөрөнгийг хугацаанд нь 100 хувь олгох үйл ажиллагааг зохион байгуулж ажилласанаар 4 томоохон үйлдвэр 10 гаруй жижиг цех шинээр байгуулагдлаа. Тус газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаман дээр 2009 оны ажлын үзүүлэлтээрээ нэгдүгээр байр эзэлсэн амжилттайгаар ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн ерөнхий менежер нь 2009 онд салбарын хэмжээнд дэвшүүлсэн зорилт, холбогдох хууль тогтоолуудыг хэрэгжүүлж гэрээгээр хүлээсэн үүргээ “А” буюу 92,5 хувьтай биелүүллээ.

Орон нутгийн хэмжээнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгслийн баталгаажуултыг 95 хувьд хүргэж, стандартгүй үйлчилгээнүүдэд шалгуур үзүүлэлт тогтоон үнэлгээ хийж, бүтээгдэхүүн үйлчилгээний тохирлын үнэлгээнд хамрагдалтыг өмнөх оноос 20 хувиар нэмэгдүүллээ.

Цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж “Алтан намар-2009” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 5 номинацаар экологийн цэвэр бүтээгдэхүүнээ шалгаруулж урамшуулан үйлдвэржүүлэлтийн бодлогыг дэмжиж “Шилдэг үйлдвэрлэгч” шалгаруулах болзолт уралдаан зарлаж дүгнэж ажиллаа.

Аймгийн Засаг даргаас Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга ерөнхий менежер нь гэрээгээр хүлээсэн үүргээ сайн биелүүлж, 81.8 хувь буюу “В” үнэлгээтэй дүгнэгдсэн бөгөөд дараахь ажлуудад ахиц гаргасан байна.

Ойн хөнөөлт хортон шавьж устгах ажлыг 6 сумдад нийт 9000 га талбайд хийж, төлөвлөгөөний биелэлтийг 4 дахин, ойжуулалтын ажлыг 969.4 га талбайд хийж, биелэлтийг 1.8 дахин, уул уурхайн нөхөн сэргээлтийг 1.4 дахин давуулан биелүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын батлагдсан төсөв 149423200 төгрөгөөс 148730293 төгрөг зарцуулж, 692907 төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас Газрын харилцаа, барилга хот байгуулалтын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан үр дүнгийн гэрээнд нийлүүлбэл зохих нийт 59 бүтээгдэхүүн, тусгай захиалгат бүтээгдэхүүн 6 , өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 3 зорилт дэвшүүлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ 87.7 хувь буюу “В” үнэлгээтэй биелүүлсэн.

Газрын харилцааны салбарын Боловсон хүчний хангамжийг сайжруулахад анхаарч мэргэжлийн боловсон хүчнээр 100 хувь хангагдаж, Аймаг сумын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний чанарыг сайжруулсан.

Газрын төлбөрийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах зорилт тавьж, ажилласнаар 174.7 мянган төгрөгийг төсөвт оруулж, төлөвлөгөөний биелэлтийг 100.9 хувиар биелүүлсэн дүнтэйгээр ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас Статистикийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан гэрээний биелэлт “92,0” оноо буюу “А” дүнтэй үнэлэгдлээ. Гол үр дүн нь оролцооны аргаар өрх, хүн амын амьжиргааны түвшин тогтоох үзлэгийг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж, үзлэгийн үр дүнд хяналт, шинжилгээ хийн үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээг төлөвлөн “Өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулан аймгийн ИТХ-ын ээлжит 3 хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Мөн албан ёсны статистик мэдээний хамралт өмнөх өнөөс нэмэгдсэн, статистикийн судалгааны ажилд ахиц өөрчлөлт гарч мэдээний тасалдал эрс багассан, өөрийн вэб сайтыг интернэтэд байршуулж, статастикийн мэдээллээр хэрэглэгчдийг хангаж ажиллаж байна.

Аймгийн Засаг даргаас Татварын хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Байгуулсан гэрээний биелэлт “90,3” оноо буюу “А” дүнтэй үнэлэгдлээ. Гол үр дүн нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 100,9 хувь, улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 103,3 хувьтай биелсэн. Татварын хяналт шалгалтын түвшин, татварын өр барагдуулалт, татварын тайлан хүлээн авалт, татвар төлөгчдийг бүртгэлд хамруулж, татварын бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтын түвшин, татвар төлөгчдийг татварт хамруулсан байдал зэргийг татварын стандарт түвшинд барьж хангаж ажилласан болно.

Аймгийн Засаг даргаас Онцгой байдлын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Онцгой байдлын газрын дарга нь байгуулсан үр дүнгийн гэрээнд нийлүүлбэл зохих нийт 72 бүтээгдэхүүн, тусгай захиалгат бүтээгдэхүүн 10 өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 3 зорилт дэвшүүлэн ажиллаж, гэрээгээр хүлээсэн үүргээ 98,5 хувь буюу “А” үнэлгээтэй биелүүлсэн бөгөөд ажлаараа Онцгой байдлын ерөнхий газарт тэргүүн байр эзэлсэн амжилттай ажилалаа.

Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ аймгийн хэмжээнд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг албан байгууллага, аж ахуй нэгж, сум, албадын хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр, газрын жилийн ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар тус тус батлуулан

ажилласан байна. Онцгой байдлын даргын 04 тоот тушаалаар гал унтраах бие бүрэлдэхүүнийг айл өрхүүдээр явуулж санаж тараан, зам гарц, объектийн судалгаа хийж ажиллаа. Мөн 2009 онд болсон цаг агаарын аюултай үзэгдлийг ОБЕГ-аас авч аймгийн Ус цаг уурын орчин шинжилгээний төвтэй хамтран иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргаас Мэргэжлийн хяналтын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Мэргэжлийн хяналтын газрын дарга нь нийт 23 ангийн 440 бүтээгдэхүүн нийлүүлж ажилласнаар 98,6 хувийн биелэлтэйгээр үнэлэгдлээ.

Гэрээгээр гүйцэтгэсэн ажлуудаас нийгмийн даатгалын сангийн хөрөнгө бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж холбогдох зөрчлийг арилгуулсан, орон нутгийн сангуудын үйл ажиллагааг, эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах зэрэг хэд хэдэн хуулийн тодорхой заалтуудыг шалгаж аймагт үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн хоолны газруудын үйл ажиллагаанд шалгалт хийж зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж ажиллаа. Мөн тус газраас нийт төсвийн 80 байгууллага, төрийн болон орон нутгийн оролцоотой 4 байгууллагын 2765 хүнийг хамруулан хяналт шалгалтыг хийж ажилласаны дээр шалгалтын 87 хувь нь төлөвлөгөөт, 13 хувь нь төлөвлөгөөт бус хяналт шалгалт эзэлж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2 удирдамжаар шалгалт хийж, шалгалтын дүнг хугацаанд нь хүргүүлээ.

Аймгийн Засаг даргаас Цагдаагийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтэс 2010 онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хангаж ажилласны дотор байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, иргэд олон нийттэй ойрхон ажиллах тал дээр идэвхи санаачлагатай ажиллаж, Алба хаагчдийн сахилга ёс зүйг сайжруулах талаар амжилт гаргаж гэрээний биелэлтийг 93,6 хувь буюу А үнэлгээтэй дүгнэгдлээ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 8,0 сая төгрөгөөр иж бүрэн тоногдсон эргүүлийн автомашин, ОХУ-ын Буриад улсын хамтын ажиллагааны хүрээнд хандиваар ирсэн Фургон автомашиныг Цагдаагийн хэлтсийн шуурхай албанд хүлээлгэн өглөө. Мөн Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймгийн Засг дарга, Хүүхдийн төлөө хэлтэс, Боловсрол соёлын газар, “Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллагын Булган орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Булган сумын ЗДТГ, Цагдаагийн хэлтэс хамтран цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2009” уламжлалт тэмцээнийг амжилттай зохион явууллаа.

Аймгийн Засаг даргаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт:

Аймгийн Засаг даргын дэргэдэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанаас шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийг сүүлийн гурван жилийн дунджаас бууруулахгүй гэсэн зорилт тавьж ажилласан бөгөөд гүйцэтгэх хуудасны болон бодит биелэлтийн хувийг сүүлийн гурван жилийн дунджаас бууруулалгүй ажиллаж, цагдан хорих байрны оргодол болон өвчлөлт гаргалгүй ажиллаж гэрээний үүргээ 92 хувьтай А үнэлгээтэй биелүүллээ.

Аймгийн Засаг даргаас түүний Тамгын газрын даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний хэрэгжилт:

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийт 57 бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бүтээгдэхүүн тус

бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв. Үүнд:

Тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийлүүлбэл зохих бүтээгдэхүүний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
57	0 - 30	25,9

Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээний бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд тухайн жилд чухал ач холбогдолтой гэж сонгож авсан тусгай захиалгат 39 бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв. Үүнд:

Нийлүүлбэл зохих тусгай захиалгат бүтээгдэхүүний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
39	0 - 40	33,6

2.3. Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх талаар Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнд тусгагдсан зорилт тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцож дор дурдсан дундаж оноогоор үнэлэв. Үүнд:

Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтын тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
8	0 - 30	29,25

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР